



ЗАСАГ ДАРГА

Б.АЗЖАРГАЛ

**ЗӨВЛӨМЖ**

“Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай”  
Сумдын ЗДТГ, Засаг даргын эрхлэх асуудлын  
хүрээний агентлагуудын 2025 оны гүйцэтгэлийн  
төлөвлөгөөний, тайлангийн хэрэгжилтийн хүрээд)

**Үндэслэл**

Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоол, тогтоолын 3 дугаар хавсралт “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 2.4, 2.5, 2.5.1, 2.5.2, 2.5.3, 3.7, 3.7.1, 3.7.2, 3.7.3, 3.8-ын заалтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд, бодлогын баримт бичгийн үр дүнд хүрэх явцыг тогтмол хугацаанд ажиглан, зөв чиглүүлэх зорилгын хүрээнд тайлангийн хэрэгжилтийн алдаа оноо, бодит үр дүн, үнэтэй сургамжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын бодлогын хэлтэс (ТЗУХ, ХЭЗХ, ХБТХОХ, СТСХ, НБХ,-)үүд, Сумдын ЗДТГ, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нэгж, агентлагууд, Орон нутгийн өмчит ААТҮГ, соёлын байгууллагуудад зөвлөж байна.

**Нэг: Сумдын Засаг даргын Тамгын газар**

Дархан-Уул аймгийн Сумдын ЗДТГ нь аймгийн Засаг даргатай гэрээний үүргийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг ирүүлэхдээ, 43 дугаар журмын 3 дугаар хавсралтын 3.7, 3.7.1, 3.7.2, 3.7.3, 3.8-ын заалтын дагуу, байгууллагын хяналт- шинжилгээ, үнэлгээний багаар үнэлүүлж ирүүлэх ёстой байсан. Гэвч бүгд 43 дугаар журмын 2.4, 2.5, 2.5.1, 2.5.2, 2.5.3-ын дагуу үнэлгээ хийж ирүүлсэн алдаа байна. Нийтлэг дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

**Цаашид анхаарах асуудал:**

1. 2026 оны төлөвлөгөө боловсруулахдаа 43 дугаар журмын 3 дугаар хавсралтын 3.7, 3.7.1, 3.7.2, 3.7.3, 3.8-ын дагуу төлөвлөж, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг зөв томъёолж, шалгуур үзүүлэлт бүр дээр үнэлгээ хийхээр тусгах.
2. Засгийн газрын 43 дугаар журмын дагуу, зөв үнэлгээний системээр үнэлэх.
3. Тайланг үнэлж, дүгнэсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний багийн үнэлгээний нэгтгэл хүснэгттэй ирүүлэх.
4. Үр дүнг тооцож ирүүлэх. (үйл ажиллагааг тусгаад, үр дүнг тооцоогүй байна.)
5. Нэг хийсэн ажлаа өөр заалт дээр давхар бичиж ирүүлсэн алдаа байна.
6. Шалгуур үзүүлэлт тус бүр дээр үнэлгээ хийж, ирүүлэх.

7. Төлөвлөгөө оновчтой, олон нийлмэл ойлголтуудыг салгаж, шалгуур үзүүлэлт тус бүрийг зөв илэрхийлэх.
8. Гэрээний заалтын тоо, дугаарлалт дээр анхаарах.
9. Гэрээнд тусгасан заалтын хэрэгжилт, оновчтой байх.
10. Хяналт-шинжилгээ үнэлгээний багаар үнэлгээ хийж ирүүлсэн нэгтгэл хүснэгтийн арга хэмжээ, зорилтын тоо, тайлантайгаа зөрдөг

**Алдаатай жишээ 1:**

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			
	Зарцуулсан хөрөнгө	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт / хүрээгүй бол тайлбар /
<p>Харьяалах сумдын хэмжээнд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үйл ажиллагаа, бэлчээрийн фото мониторингийн судалгааны ажлыг эрчимжүүлэх, газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, сумдын шинэчлэх шаардлагатай газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, боловсруулж, батлуулах, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэх, өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөж, хэрэгжилтийг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах;</p>	0,5 тэрбум	Газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах	Газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан хэрэгжүүлэх	<p>Тус сумын хэмжээнд газрын хянан баталгааны 455 тайлан баталгаажсан байна.</p> <p>Сумын хэмжээнд эвдэрсэн газрын тооллогыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Байгаль орчны газартай хамтран зохион байгуулсан бөгөөд өмнөх оноос нэмж 1 байршил бүртгэгдсэн. 2025 онд 1 ААНБ 0.85 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийн, аймгийн Байгаль орчны газар актаар хүлээн авсан.</p> <p>Сумын ИТХ-ын 2025 оны "Тухайн сумын жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний нэмэлт тодотгол оруулах тухай" 05 дугаар тогтоолоор 4 нэгж талбарт 1,3га талбайд нэмэлт тодотгол хийсэн.</p> <p>Сумын 2026 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийт 35 иргэн, ААНБ-ын саналыг тусгуулахаар аймгийн ГХБХБГ-т уламжилсан.</p> <p>Сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан "2025 оны Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-ний хэрэгжилт 73.5%-тай байна. <b>Хэрэгжилт: 80%</b></p>

A1: Арга хэмжээг төлөвлөхдөө 7 үйл ажиллагааг 1 арга хэмжээнд тусгасан нь хэтэрхий олон байна.

A2: Долоон арга хэмжээнд 3 шалгуур үзүүлэлт хэтэрхий бага байна.

A3: Долоон арга хэмжээний хүрэх түвшин 1 байна.

A4: 43 дугаар журмын 3.7, 3.8-ын заалтын дагуу үнэлээгүй

A5: Хүрсэн түвшин 7 арга хэмжээ тус бүртэй нийцэхгүй (зарим нь)

A6: Үр дүнг тооцоогүй байна. (Хүрсэн түвшин холилдоод, ойлгоход хүндрэлтэй байна.)

**Сайжруулсан жишээ:**

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			
	Зарцуулсан хөрөнгө	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт / хүрээгүй бол тайлбар /
<p>1.1.Харьяалах сумдын хэмжээнд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үйл ажиллагаа, бэлчээрийн фото мониторингийн судалгааны ажлыг эрчимжүүлэх, газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах,</p>	0,5 тэрбум	Судалгааны ажлыг эрчимжүүлэх, тайланг баталгаажуулах	3 төрлийн судалгаа хийгдсэн, үр дүн тодорхойлогдсон байна	Тус сумын хэмжээнд газрын хянан баталгааны 455 тайлан баталгаажсан байна.  Үр дүн: ????? (Хэрэгжсэн, хэрэгжээгүй, хугацаа болоогүй 3 шатлалаар үнэлгээ хийнэ.)
		Газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх	Газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлсэн байна.	Сумын хэмжээнд эвдэрсэн газрын тооллогыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Байгаль орчны газартай хамтран зохион байгуулсан бөгөөд өмнөх оноос нэмж 1 байршил бүртгэгдсэн. 2025 онд 1 ААНБ 0.85 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийн, аймгийн Байгаль орчны газар актаар хүлээн авсан. Сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “2025 оны Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-ний хэрэгжилт 73.5%-тай байна. Хэрэгжилт: 80% Үр дүн: ????
		Газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах	Шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.	Сумын ИТХ-ын 2025 оны “Тухайн сумын жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний нэмэлт тодотгол оруулах тухай” 05 дугаар тогтоолоор 4 нэгж талбарт 1,3га талбайд нэмэлт тодотгол хийсэн.  Үр дүн:????
		Төлөвлөгөө батлуулах, санхүүжилтийг шийдвэрлүүлэх	Арга хэмжээний тоо, санхүүжилтийн дүн	Сумын 2026 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийт 35 иргэн, ААНБ-ын саналыг тусгуулахаар аймгийн ГХБХБГ-т уламжилсан.  Үр дүн:????
1.2.Сумдын шинэчлэх шаардлагатай газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, боловсруулж, батлуулах, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэх, өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөж, хэрэгжилтийг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах;		Хууль тогтоомжийн дагуу хэрэгжилтийг хангах	Газрын байршил хэмжээ тодорхойлогдсон, хэрэгжилт хангагдсан байна.	Үйл ажиллагаа:  Үр дүн: ??????

**Тайлбар:** Долоон агуулагатай заалтыг 2 болгож багцлан, шалгуур үзүүлэлтүүдийг утгаар нь ялгасан. Нэг арга хэмжээнд хэдэн ч шалгуур үзүүлэлт байж болно. Арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин хоорондоо уялдаатай байх, үйл ажиллагаа, үр дүнгээ заавал тодорхой тусгах.

**Хоёр: Хэлтэс, агентлагууд**

Дархан-Уул аймгийн Засаг даргын харьяа бодлогын хэлтэс агентлагууд 2025 оны жилийн эцсийн байгууллагын гүйцэтгэлийн тайлангаа ирүүлэхдээ, ихэнх байгууллагууд 301

дүгээр журмын дагуу үнэлгээ хийж ирүүлсэн алдаа байна. Нийтлэг дараах зөвлөмжийг хүргүүлж байна

**Цаашид анхаарах асуудал:**

1. 2026 оны төлөвлөгөө боловсруулахдаа 43 дугаар журмын 3 дугаар хавсралтын 2.4, 2.5, 2.5.1, 2.5.2, 2.5.3-ын дагуу төлөвлөж, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг зөв томъёолж, шалгуур үзүүлэлт бүр дээр үнэлгээ хийхээр тусгах.
2. Засгийн газрын 43 дугаар журмын дагуу, зөв үнэлгээний системээр үнэлэх.
3. Тайланг үнэлж, дүгнэсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний багийн үнэлгээний нэгтгэл хүснэгттэй ирүүлэх.
4. Үр дүнг тооцож ирүүлэх. (үйл ажиллагааг тусгаад, үр дүнг тооцоогүй байна.)
5. Нэг хийсэн ажлаа өөр заалт дээр давхар бичиж ирүүлсэн алдаа байна.
6. Шалгуур үзүүлэлт тус бүр дээр үнэлгээ хийж, ирүүлэх.
7. Төлөвлөгөө оновчтой, олон нийлмэл ойлголтуудыг салгаж, шалгуур үзүүлэлт тус бүрийг зөв илэрхийлэх.
8. Арга хэмжээний тоо, дугаарлалт дээр анхаарах.
9. Арга хэмжээнд тусгасан заалтын хэрэгжилт, оновчтой байх.
10. Хяналт-шинжилгээ үнэлгээний багаар үнэлгээ хийж ирүүлсэн нэгтгэл хүснэгтийн арга хэмжээ, зорилтын тоо, тайлантайгаа зөрөхгүй байх.
11. Тайлангаа ар цаасан дээр хэвлэж ирүүлэхгүй байх.

**Алдаатай жишээ 2:**

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Өөрийн үнэлгээ	ХШ
1.1.3	Шинээр бий болсон ажлын байрыг бүртгэх, мэдээлэх ажлыг зохион байгуулах	-	-Шинээр бий болсон ажлын байрны тоо (Шинээр бий болсон ажлын байрны 50-аас доошгүй хувь нь байнгын ажлын байр байна.)	Аймгийн хэмжээнд 2200 шинэ ажлын байр бүртгэгдэж, нийтэд мэдээлсэн.	Шинээр бий болж буй 1500 ажлын байрны мэдээллийг иргэдэд хүргэх, ажил олгогч, иргэнээс авах, сурталчилгаа, зар мэдээг олон нийтэд шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж, үйлчилгээний чанарыг сайжируулна. Шинээр бий болсон ажлын байрны мэдээллийг батлагдсан маягтын дагуу хөдөлмөр эрхлэлтийн цахим e-job системд бүртгэж, мэдээлнэ	Засгийн газрын тусгай сангууд, бусад хөтөлбөр, төслийн хүрээнд шинээр бий болсон 2214 ажлын байрыг e-job системд бүртгэж, олон нийтэд шуурхай хүргэж мэдээлсэн. Үүнд байнгын-байгуулж, 1308, улирлын болон түр ажлын байр 906 бүртгэсэн байна. Үр дүн: Ажлын байрны тоо: 2214	100	-2%

A1: Төлөвлөгөөний дугаарлалт буруу

A2: Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг олон утга санааг багцалсан

A3: Төлөвлөлт алдаатай.

**Сайжруулсан жишээ:**

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Өөрийн үнэлгээ	ХШ
1.	1.1.3. Шинээр бий болсон ажлын байрыг бүртгэх, мэдээлэх ажлыг зохион байгуулах	-	-Шинээр бий болсон ажлын байрны тоо	2200	1500	Засгийн газрын тусгай сангууд, бусад хөтөлбөр, төслийн хүрээнд 2214 ажлын байрыг шинээр бий болгосон.  Үр дүн: Ажлын байрны тоо: 2214	100	-2%
2.		-	Шинээр бий болсон ажлын байрны тоог системд бүртгэсэн байна.	2200	2214	Шинээр бий болсон ажлын байрны мэдээллийг батлагдсан маягтын дагуу хөдөлмөр эрхлэлтийн цахим e-job системд бүртгэж, олон нийтэд шуурхай хүргэж мэдээлсэн.  Үр дүн:????	100	100%
3.		-	Шинээр бий болсон ажлын байрны 50-аас доошгүй хувь нь байнгын ажлын байр байна.	1100	1308	Байнгын-1308, улирлын болон түр ажлын байр 906 бүртгэсэн байна. .... Мэдээллийг иргэдэд хүргэх, ажил олгогч, иргэнээс авах, сурталчилгаа, зар мэдээг олон нийтэд шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж, үйлчилгээний чанарыг сайжирууллаа.  Үр дүн: Байнгын 1308	100	100%

**Тайлбар:** Арга хэмжээ нэг, шалгуур үзүүлэлт хэд ч байж болно. Шалгуур үзүүлэлт, суурь түвшин зорилтот түвшингээ тоо чанараар илэрхийлэх, Үр дүнгээ заавал тодорхойлох хэрэгтэй. Мөн ерөнхий дугаарлалт арга хэмжээний дугаарлалт 2-ыг зөв дугаарлах, 43 дугаар журмын 3 дугаар хавсралтын 2.4, 2.5, 2.5.1, 2.5.2, 2.5.3-ын дагуу төлөвлөх хэрэгтэй байна. Төлөвлөлт буруугаас, үнэлгээний өөрчлөлт -2%-тай гарсан байна.Өөрөөр хэлбэл зорилтот түвшингээ хэтэрхий багаар тавьсан байна.

**Гурав: Журам**

**Хяналт-шинжилгээ хийх журам: 2025 оны 43-р тогтоолын 1 дүгээр хавсралт**

3.2. Байгууллага нь хяналт-шинжилгээний асуудал хариуцсан нэгж, эсхүл ажилтан (баг)-тай байх бөгөөд хяналт-шинжилгээний асуудал хариуцсан нэгж, эсхүл ажилтан (баг) нь зохион байгууллалтын хувьд бусад нэгжээс хараат бусаар үйл ажиллагаа явуулна.

4.4. Байгууллагын үнэлгээ, хяналт шинжилгээний нэгж, ажилтан (баг) дараах эрх, үүрэгтэй байна.

4.4.1. хяналт-шинжилгээ хийхэд шаардлагатай баримт, мэдээллийг холбогдох нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах:

4.4.4. Хяналт-шинжилгээний үр дүнд үндэслэн өгсөн зөвлөмжийг удаа дараа биелүүлээгүй, шаардлагатай баримт бичиг, мэдээлэл, бусад холбогдох нотлох баримтыг заасан хугацаанд ирүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг удирдлагад уламжлах,

4.4.6. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээг, үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтааж, үг үсгийн болон утга агуулгын алдаагүй тайлагнах.

### Дөрөв: Хариуцлага

**Хяналт-шинжилгээ хийх журам:** 2025 оны 43-р тогтоолын 1 дүгээр хавсралт

9.1. Энэ журамд заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтан холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

**Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам:** 2025 оны 43-р тогтоолын 3 дугаар хавсралт

6.1. Байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийн ерөнхий дүнгээр 2 жил дараалан ахиц өөрчлөлт гараагүй буюу “Хангалтгүй” дүгнэгдсэн салбар хариуцсан Засгийн газрын гишүүн, яамны Төрийн нарийн бичгийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга болон Тамгын газрын (нэгжийн) дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

• **ЗӨВЛӨМЖ** бол бичгээр хүрч буй **ЗӨВЛӨГӨӨ** юм.

ТАНИЛЦСАН:


ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.БАТЗУЛ

БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН



Г.ГЭРЭЛМАА